



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/483

Зуунмод

Г Газар эзэмших эрхийг баталгаажуулж,
газрын хэмжээг оорчилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын Номт 1-р баг, Соёмбо хотхон, Ж.Самбуугийн гудамж 110 тоотод эзэмшиж буй 892 м2 газрын хэмжээг одоогийн байгаа хэмжээгээр буюу 991 м2 болгон өөрчилж Тагнуулын ерөнхий газрын Төв аймаг дахь хэлтэс /9061444/- т төр захиргааны байгууллагын зориулалтаар 60 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Тагнуулын ерөнхий газрын Төв аймаг дахь хэлтэс /Л.Энхбаатар/-г дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.2. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын толборийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.3. Холбогдох хууль тогтоомж, хэсэгчилсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Монхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Зуунмод сумын Засаг даргын 2008 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 103 дүгээр захирамж болон газар эзэмших эрхийн 6794 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.



ЗАСАГ ДАРГА

ХАТГАРГАЛ